



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/МБ

Эрдэнэт

“Эрүүл Эрдэнэт хүн” үйл ажиллагаа
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Засгийн газрын 2017 оны 289 дүгээр Үндэсний хөтөлбөр батлах тухай тогтоолын 3 дугаар зүйлийн 3.2.4, 3.4.5, 3.4.7, 3.4.8, аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн сайдтай 2018 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 3.3.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн Х хуралдааны 10/02 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хүн амын дунд тулгамдаж буй асуудал болох элэг, ходоодны хавдар, сүрьеэ, бэлгийн замын өвчлөлийн талаарх мэдээллийг ард иргэдэд өгөх, өвчлөлийг эрт илрүүлэх, эмчлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын идэвх санаачлагыг өрнүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын ивээл дор “Эрүүл Эрдэнэт хүн” хөтөлбөр үйл ажиллагааг жилийн турш зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, аянд шаардагдах төсвийн тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Эрүүл Эрдэнэт хүн” туг аялуулахад ажилтан, ажиллагсад, багийн иргэдээ идэвхтэй оролцуулахыг Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг дарга нар болон төрийн болон төрийн өмчит байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, их дээд сургуулиудын захирал, дарга нарт санхүүгийн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг тус тус даалгасугай.

3. Захирамжийн дагуу хөтөлбөр үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, “Эрдэнэтийн эрүүл иргэн” төрийн бус байгууллагатай хамтран ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс /н.Бумансор/, Эрүүл мэндийн газар /н.Мөнхцэцэг/, Бүсийн оношлогоо эмчилгээний төв /н.Батсүх/, Медипас эмнэлэг /н.Энхчулуун/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Аянд шаардагдах 48000000 /Дөчин найман сая/ төгрөгийг “Эрүүл Эрдэнэт хүн” хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ



D:\zahiramj/A-4.doc

0200000619

Аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 115 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**ХӨТӨЛБӨР ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГАТАЙ
ТӨСӨВ**

№	Нэр, төрөл		Хэмжих нэгж	Тоо	Давтамж	Нэгжийн Үнэ	Нийт Үнэ		
1	Сургалт	Эмч нарын сургалт	Сургалтын төлбөр	цаг	8	2	60000	5570000	
			Бал	ш	120	1	500		60000
			Дэвтэр	ш	120	1	5000		600000
			Хоол	ш	120	1	8000		960000
			Цай	ш	120	1	2000		240000
			Бусад	ш	120	1	1000		120000
		Туг аялуулах	Дэвтэр	ш	2	1	15000		30000
			Туг	ш	2	1	100000		200000
	Иргэдийн сургалт лекц	Лекцийн төлбөр	удаа	12	1	200000	2400000		
2	Судалгаа	В вирусын халдвартай эхээс төрсөн нярайн эрсдлийн судалгаа	В-тэй ээж болон хүүхдээс шинжилгээ авах	хүн	100	1	70000	7000000	7000000
3	Ходоод, улаан хоолой	Хамрагдах хүн		хүн	100	1	68000	7500000	
		Асуумж, эрхийн бичиг		ш	500	1	1000		500000
		Бусад					200000		200000
4	Элэг	Ажиллах хүчин	ӨЭМТ эмч	хүн	9	11	20000	8060000	
			Хяналтын нарийн мэргэжлийн эмч	хүн	4	11	20000		880000
			Эмчийн үзлэг	хүн	500	2	5000		5000000
		Зохион байгууллалтын зардал							200000
5	БЗДӨ	Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, урьдчилан сэргийлэх	ЕБС сургалтын цайны зардал /9-12 анги/	ш	1,000	1	1000	6320000	
			ЕБС сургалт	цаг	2	64	40000		5120000
			Их, дээд сургууль сургалт	цаг					
			Жирэмсэн эмэгтэйчүүдийн сургалт	цаг					

		Зохион байгуулалтын бусад зардал						200000	
6	Сүрьеэ	Хамрагдах иргэд сонгох	ӨЭМТ-ийн урамшуулал	ш	500	1	1000	500000	4750000
			Урилга хэвлэх	ш	500	1	500	250000	
		Илрүүлэг	Рентген зураг авах	хүн	350	1	5000	1750000	
			Рентген зураг авах	хүн	150	1	15000	2250000	
7	Бусад	Анонс	Амарын талбай	ш	1	1	350000	350000	8800000
		Анонс /3м*2м/	Сургалтад хэрэглэх	ш	1	1	50000	50000	
		Тараах материал	Өвчлөлөөр гаргах	ш	18000	1	300	5400000	
		Плакат	Хүн ихтэй газар байрлуулах	ш	100	1	10000	1000000	
		Өвчтөн, нийгмийн төлөөллийн зөвлөл	Ходоодны хавдар эмчлүүлсэн иргэд уулзалт, зөвлөгөөний цайны зардал	Удаа	6	1	5000	300000	
			С вирусээр эмчлүүлсэн иргэд уулзалт, зөвлөгөөний цайны зардал	Удаа	6	1	50000	300000	
			В, Д вирусээр эмчлүүлсэн иргэд уулзалт, зөвлөгөөний цайны зардал	Удаа	6	1	50000	300000	
			Ахмад багш нартай уулзалт, зөвлөгөөний цайны зардал	Удаа	6	1	50000	300000	
			Өсвөрийн эмч клуб уулзалт, зөвлөгөөний цайны зардал	Удаа	6	1	50000	300000	
		Бүгд							
Хэвлэл мэдээллийн зардал							500000		
Нийт дүн							48000000		